



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠶᠢᠨ  
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ  
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ


# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# 2026 4 сар










[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

[www.1212.mn](http://www.1212.mn)



## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2022-2026 ОН	3
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	17
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ, МАЛЫН ТӨРӨЛ, ХОРООГООР

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
<b>Нийт мал</b>	<b>165 796</b>	<b>36 969</b>	<b>7 184</b>	<b>34 740</b>	<b>52 143</b>	<b>34 760</b>
Үүнээс:						
Тэмээ	42	15	-	24	-	3
Адуу	21 685	5 837	1 083	4 670	5 048	5 047
Үхэр	22 930	5 731	1 634	4 944	6 121	4 500
Хонь	70 597	14 707	2 660	14 871	24 294	14 065
Ямаа	50 542	10 679	1 807	10 231	16 680	11 145

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ IV САРД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	I-IV				
		2022	2023	2024	2025	2026
<b>Суурин хүн ам</b>	<b>тоо</b>	<b>29 341</b>	<b>28 926</b>	<b>29 152</b>	<b>28949</b>	<b>-</b>
Төрөлт	тоо	163	210	148	121	137
Нас баралт	тоо	65	41	56	51	48
Шилжиж ирсэн	тоо	221	261	338	206	406
Цэвэр өсөлт	хувь	0.33	0.58	0.32	0.24	0.31'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2025 ОН






## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст 89 иргэн идэвхтэй ажил хайж бүртгүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 22 (19.7%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 4 дүгээр сард, тоогоор




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 71 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 31 (43.7%) нь эмэгтэйчүүд эзэлж байгаа ба дараах шалтгаанаар нэмэгдсэн

байна. Мөн энэ хугацаанд 12 иргэн ажилд зуучлуулан орж, 32 иргэний бүртгэл идэвхгүй болсон байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ШАЛТГААНААР, 4 дүгээр сард, тоогоор



ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, тоо, хувиар



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 4 (4.5%) нь 15-24 насны, 24 (27.0%) нь 25-34 насны залуучууд, 33 (37.0%) нь 35-44

насныхан, 24 (27.0%) нь 45-60 насныхан, 4 (4.5%) нь 60+ насныхан эзэлж байна.

### ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, 4 дүгээр сард

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо			Үүнээс: эмэгтэй		
	2024	2025	2026	2024	2025	2026
	тоогоор					
<b>Ажилгүйдлийн бүгд</b>	<b>62</b>	<b>111</b>	<b>89</b>	<b>29</b>	<b>49</b>	<b>38</b>
Үүнээс:						
Дээд боловсролтой	24	37	31	16	26	19
Тусгай дунд боловсролтой	6	6	5	2	2	1
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	7	12	3	2	2	1
Ерөнхий боловсролтой	25	51	50	9	19	17
Бага болон боловсролгүй	-	5	-	-	-	-

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 31 (34.8%) нь дээд боловсролтой, 5 (5.6%) нь тусгай дунд боловсролтой, 3 (3.4%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой,

50 (56.1%) нь ерөнхий боловсролтой иргэд ажээ. Ажил хайгч иргэдийн 38 (42.7%) нь эмэгтэйчүүд байна.




## НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангийн орлого 13.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.6 (52.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 10.7 (81.0%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 1.1 (8.6%) тэрбум төгрөг тэтгэмжийн сангаас, 980.8 (7.4%) сая төгрөг үйлдвэрлэлийн осол,

мэргэжлээс шалтгаалах өвчний сангаас, 408.9 (3.0%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
	сая төгрөг				
<b>Сангийн орлого, бүгд</b>	<b>10 539.0</b>	<b>8 705.2</b>	<b>13 301.9</b>	<b>4 596.7</b>	<b>52.8</b>
тэтгэврийн сан	8 525.0	7 262.5	10 768.9	3 506.4	48.3
тэтгэмжийн сан	887.2	632.8	1 143.3	510.5	80.7
ҮОМШӨ <sup>1</sup> -ний сан	787.7	568.9	980.8	411.9	72.4
Ажилгүйдлийн сан	339.1	241.0	408.9	167.9	69.7
<b>Сангийн зарлага, бүгд</b>	<b>19 200.7</b>	<b>22 323.3</b>	<b>25 566.7</b>	<b>3 243.4</b>	<b>14.5</b>
тэтгэврийн сан	16 674.6	20 207.0	22 739.2	2 532.2	12.5
тэтгэмжийн сан	878.5	839.2	957.3	118.1	14.1
ҮОМШӨ <sup>1</sup> -ний сан	1 177.7	779.8	856.7	76.9	9.9
Ажилгүйдлийн сан	469.9	497.3	1 013.5	516.2	103.8

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Сангийн зарлага 25.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.2 (14.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд тус сангаас 5395 хүнд 22.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 467 хүнд 957.3 сая төгрөгийн тэтгэмж, 145 хүнд 856.7 сая

төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 142 хүнд 1.0 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



**НИЙГМИЙН ХАЛАМЖ**

Нийгмийн халамжийн сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 459.6 (6.8%) сая төгрөгөөр өссөн байна.

<sup>1</sup> Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 514 хүнд 932.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 466 хүнд 634.1 сая төгрөгийн асаргааны тэтгэмж, 291 хүнд 257.5 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 231 жирэмсэн

эхэд 21.3 сая төгрөгийн тэтгэмж, 10785 хүүхдэд 4.3 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асардаг 957 эцэг, эхэд 166.3 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

#### ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
	сая төгрөг				
<b>Сангийн зарлага</b>	<b>6 221.4</b>	<b>6 754.1</b>	<b>7 213.7</b>	<b>459.6</b>	<b>6.8</b>
Нийгмийн халамжийн тэтгэвэр	614.8	738.1	932.2	194.1	26.3
Асаргааны тэтгэмж	409.1	478.0	634.1	156.1	32.7
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	155.4	183.3	257.5	74.2	40.5
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	109.4	214.6	213.2	- 1.4	- 0.7
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	171.2	355.0	370.0	15.0	4.2
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	24.6	23.3	21.3	- 2.0	- 8.6
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	4 244.0	4 280.3	4 257.8	- 22.5	- 0.5
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	200.6	178.2	166.3	- 11.9	- 6.7
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	41.0	44.5	84.6	40.1	90.1
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	5.3	4.9	12.9	8.0	163.3
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	51.0	48.0	20.4	- 27.6	- 57.5
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	44.0	45.7	60.6	14.9	32.6
Оршуулгын тэтгэмж	6.0	8.0	12.0	4.0	50.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	6.0	2.0	8.0	6.0	3.0 <sup>1</sup>
Онцгой тохиолдлын тэтгэмж	1.2	4.8	1.2	- 3.6	- 75.0
Насны хишиг	137.8	145.4	161.6	16.2	11.1

<sup>1</sup>-дахин их

Мөн 326 ахмад настанг 84.6 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламжинд, 378 өрхийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 20.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 55 иргэдэд 12.9 сая төгрөгийн хөнгөлөлт, өрх толгойлсон 81 эцэг эхэд 60.6 сая

төгрөгийн тэтгэмж, 2006 иргэнд 161.6 сая төгрөгийн насны хишиг, 4 иргэнд 12.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, 4 иргэнд 8.0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмж, 1 иргэнд 1.2 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмжийг тус тус олгожээ.



## ЭРҮҮЛ МЭНД

Салхин цэцэг өвчний 89 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний (61.0%) эзэлж байна.

2026 оны эхний 4 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 35 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 24.0%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 (2.8%) тохиолдлоор буурсан бол, цочмог халдварт өвчний 111 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний


76.0%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 48 (76.2%) тохиолдлоор өссөн байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 50.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.3 продицмиллээр өссөн байна.


### ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
<b>Нийт халдварт өвчин</b>	<b>80</b>	<b>99</b>	<b>146</b>	<b>47</b>	<b>47.5</b>
<b>Бэлгийн замын халдварт өвчин</b>	<b>35</b>	<b>36</b>	<b>35</b>	<b>-1</b>	<b>-2.8</b>
Заг хүйтэн	19	18	27	9	50.0
Тэмбүү	11	12	8	-4	-33.3
Трихомониаз	2	4	-	-4	-100.0
Кандилом	1	2	-	-2	-100.0
Хомхой	1	-	-	-	-
Хламид	1	-	-	-	-
<b>Цочмог халдварт өвчин</b>	<b>45</b>	<b>63</b>	<b>111</b>	<b>48</b>	<b>76.2</b>
Цусан суулга	6	1	1	-	0.0
Гипатит А	-	1	-	-1	-100.0
Скарлатин	-	-	2	2	-
Салхин цэцэг	29	47	89	42	89.4
Улаанбурхан	-	2	1	-1	-50.0
Рож	2	-	-	-	-
Гар хөл амны өвчин	-	2	15	13	6.5 <sup>1</sup>
Гэдэсний халдвар	-	-	1	1	-
Сүрьеэ	8	8	2	-6	-75.0

ЗУРАГ 7. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ЗУРАГ 8. ЭМНЭЛГИЙН НИЙТ ҮЗЛЭГ, эхний IV сард



ХҮСНЭГТ 7. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
Амаржсан эхийн тоо	162	136	149	13.0	9.6
Үүнээс бусад аймгийн харьяат	60	56	50	-6.0	-10.7
Амьд төрсөн хүүхэд	161	134	151	17.0	12.7
Үүнээс бусад аймгийн харьяат	47	56	50	-6.0	-10.7
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	2	2	2	0.0	0.0

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 4 сарын байдлаар 149 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 13 (9.6%) өссөн байна. Энэ хугацаанд 78.8 мянган хүн эмнэлгийн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс

3.3 (4.0%) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 2.4 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 (22.8%) мянган хүнээр тус тус буурсан байна.



## ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд оны эхний 4 сард 137 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 52 (27.5%) хэргээр буурсан бол, илрүүлэлт 45.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 12.0 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний IV сард, төрлөөр

Хэргийн төрөл	I-IV			Өөрчлөлт	
	2024	2025	2026	тоо	хувь
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд</b>	<b>114</b>	<b>189</b>	<b>137</b>	<b>-52</b>	<b>-27.5</b>
Хүнийг алах	2	1	1	0	0.0
Хүний амь нас хохирсон	-	2	2	0	0.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	47	61	55	-6	-9.8
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	2	8	6	-2	-25.0
Бусдын эд хөрөнгө хулгайлах	14	29	19	-10	-34.5
Мал хулгайлах	-	1	-	-1	-100.0
Залилан мэхлэх	20	39	17	-22	-56.4
Дээрэмдэх	-	2	-	-2	-100.0
Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	-	1	-	-1	-100.0
Заналхийлэх	-	-	2	2	-
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	12	8	1	-7	-87.5
Татвар төлөхөөс зайлсхийх	-	1	1	0	0.0
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	-	3	2	-1	-33.3
Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах	-	1	-	-1	-100.0
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	-	-	1	1	-
Мөнгөн тэмдэгч үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл, хуурамчаар бэлтгэх ашиглах	6	3	-	-3	-100.0
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	1	-	-	0	-
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	1	-	2	2	-
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	1	1	2	1	100.0
Хууль бусаар мод бэлтгэх	-	-	1	1	-
Худал мэдээлэл тараах	-	1	-	-1	-100.0
Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	-	-	1	1	-
Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах	1	-	-	0	-
Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэнд оруулах	-	-	1	1	-
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	-	1	9	8	9.0 <sup>1</sup>
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	7	5	1	-4	-80.0
Давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	-	21	13	-8	-38.1
<b>Хэрэг илрүүлэлтийн хувь</b>	<b>41.3</b>	<b>33.5</b>	<b>45.5</b>		

<sup>1</sup>-дахин их


ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнхийг буюу 55 (40.1%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 19 (13.9%) нь хулгайлах хэрэг, 17 (12.4%) нь залилан мэхлэх хэрэг, 13 (9.5%) нь давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хэрэг, 9 (6.6%) нь цахим мэдээлэлд хууль бусаар халдах хэрэг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэг 6

(4.4%), хүний амь нас хохирсон хэрэг, заналхийлэх гэмт хэрэг, бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх хэрэг, мансууруулах эм сэтгэцэт нөлөөт эм бодисыг хууль бусаар ашигласан хэрэг, автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явсан хэргүүд тус бүр 2 (7.3%), бусад хэргүүд тус бүр 1 (5.8%) бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний IV сард




ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний IV сард



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өөрчлөлт	
	2024	2025	2026	тоо	хувь
<b>Гэмт хэрэгт холбогдсон хүн</b>	<b>57</b>	<b>82</b>	<b>82</b>	-	-
Үүнээс: эмэгтэйчүүд	10	10	17	7	70.0
хүүхэд	3	6	6	-	-
<b>Гэмт хэргийн улмаас хохирсон хүн</b>	<b>104</b>	<b>172</b>	<b>124</b>	<b>-48</b>	<b>-27.9</b>
Үүнээс: нас барсан	1	6	5	-1	-16.7
гэмтсэн	50	70	60	-10	-14.3
Согтуугаар зөрчил гаргаж саатуулагдсан хүний тоо	53	94	42	-52	-55.3
Баривчлагдсан хүний тоо	39	39	26	-13	-33.3
Учирсан хохирол /сая төгрөг/	202.3	841.0	271.5	-569.5	-67.7
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	29.7	121.0	33.5	-87.5	-72.3

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, оны IV эхний сард



2026 оны эхний 4 сард 82 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 17 (20.7%) нь эмэгтэйчүүд, 6 (7.3%) нь 18 хүртлэх насны хүүхэд тус тус бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 124 иргэн гэмт хэргийн улмаас хохирсны 60 (48.4%) нь гэмтсэн иргэд бөгөөд нас барсан иргэн 5 (4.0%) бүртгэгдсэн байна.

Мөн 42 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 26 иргэн баривчлагдсан нь өмнөх оноос согтуугаар зөрчил гарган саатуулагдсан иргэд 52 (55.3%) нэгжээр, баривчлагдсан иргэд 13 (33.3%) нэгжээр тус тус буурсан байна.


Гэмт хэргийн улмаас 271.5 сая төгрөгийн хохирол учирсны 33.5 (12.3%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.



## ҮНЭ ХАНШ

Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ЗУРАГ 14. "АЛТАН ТАРИА" ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард



ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, IV сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжээ ЖЛӨН	4.03	4.10	4.17	4.24
"Алтан гурил тариа"	Дээд	кг	4 000	4 000	4 000	4 000
	I зэрэг	кг	3 000	3 000	3 000	3 000
	II зэрэг	кг	2 200	2 200	2 200	2 200
Будаа	цагаан	кг	3 900	3 900	3 900	3 900
	шар	кг	3 200	3 200	3 200	3 200
Хонины мах	ястай	кг	17 500	20 000	21 000	21 000
	цул	кг	22 000	23 500	24 000	24 000
Үхрийн мах	ястай	кг	23 000	23 500	25 000	26 000
	цул	кг	28 000	28 500	30 250	31 500
Адууны мах, ястай		кг	12 000	15 000	16 750	17 260
Ямааны мах		кг	13 000	15 000	16 750	18 100
Элсэн чихэр		кг	4 000	4 000	4 000	4 000
Сүү /задгай/		л	4 000	4 000	4 000	3 000
Тараг /задгай/		л	4 500	4 500	4 500	3 500
Цөцгийн тос, Орос		кг	6 000	6 000	6 000	6 000
Байцаа		кг	3 000	3 000	3 000	3 000
Манжин		кг	3 500	3 500	3 500	3 500
Төмс	монгол	кг	3 000	2 800	2 800	2 800
Лууван	монгол	кг	2 900	3 000	3 000	3 000
Сонгино	хятад	кг	2 500	2 500	2 500	2 500
	монгол	кг	3 500	3 500	3 500	3 500
Сармис, булцуу		ш	650	650	650	650
Огурцы, хятад		кг	11 000	10 500	10 500	9 000
Помидор, хятад /үрлэн/		кг	10 500	9 000	9 000	8 500
Ургамлын тос/ siesta/		ш	12 000	12 000	12 000	12 000
Өндөг		ш	550	580	550	550
Атар талх		ш	2 700	2 700	2 700	2 700

ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард



ХҮСНЭГТ 11. ДУЛААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Ангилал	Хэмжих нэгж	Тариф	
Орон сууцны халаалт (Оюутны байр, подвол, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	төг/м <sup>2</sup>	845	
	төг/ГДж	11 150	
Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор Халаалтын улиралд	төг/хүн	4 049
	Халаалтын бус улиралд	төг/хүн	5 668
	Усны зарцуулалтаар	төг/м <sup>3</sup>	2 089
Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тариф			
40м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	төг/сар	4 224	
41м <sup>2</sup> -аас 80м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	төг/сар	7 040	
81м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	төг/сар	14 080	
Үйлдвэр, аж ахуйн нэгжийн дулааны эрчим хүчний тариф			
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	төг/м <sup>3</sup>	1 487	
	төг/ГЖ	23 767	
Багануур ХК-ийн халаалт	төг/ГЖ	33 234	
Төсвийн байгууллагын халаалт	төг/м <sup>3</sup>	1 549	
	төг/ГЖ	29 693	

ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф
1. Айл өрхийн цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	175.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц	төг/квт.ц	256.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	285.0
Хоёр тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	182.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	147.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	225.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	160.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	265.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	160.0
Гурван тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	170.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	280.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		

Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	190.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	290.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	220.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	300.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын суурь тариф	төг/сар	3 200
2. Уул уурхай, үүрэн холбооны үйлчилгээнээс бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны тариф		
Энгийн тоолууртай	төг/квт.ц	265.0
Гурван тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	265.0
Оройн хэрэглээ /17.00-22.00/	төг/квт.ц	397.0
Шөнийн хэрэглээ /22.00-06.00/	төг/квт.ц	160.0

\*2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж буй тариф

### ХҮСНЭГТ 13. УСНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	1 гкал	84 272
		1м <sup>3</sup> (тоолууртай)		
	Зун	1 хүн (тоолуургүй)		
		1м <sup>3</sup> (тоолууртай)		
Цэвэр ус <sup>2</sup>	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус түгээх байраар	2.72		
Бохир ус <sup>2</sup>	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус соруулах	15.0		

### ХҮСНЭГТ 14. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2022 IV	2023 IV	2024 IV	2025 IV	2026 IV
	төгрөг				
АИ -92	2 440	2 440	2 440	2 440	2 640
Дизель түлш	3 265	3 800	3 990	3 240	4 650

2026 оны 4 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 200 (8.2%)

төгрөгөөр, дизель түлш 1410 (43.5%) төгрөгөөр тус тус өссөн байна.



## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 105.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (0.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	I-IV			Өөрчлөлт	
	2024	2025	2026	дүн	хувь
<b>Нийт дүн</b>	<b>85 913.1</b>	<b>106 691.9</b>	<b>105 699.0</b>	<b>-992.9</b>	<b>-0.9</b>
Нүүрс олборлолт	79 794.3	98 580.8	97 661.2	-919.6	-0.9
Дулаан дамжуулалт	5 359.8	6 763.4	6 431.8	-331.6	-4.9
Талх, нарийн боов	380.6	435.9	518.0	82.1	18.8
Зайлуулсан хог хаягдал	378.4	911.8	1 088.0	176.2	19.3


ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, биет хэмжээгээр

Үзүүлэлт	I-IV			Өөрчлөлт	
	2024	2025	2026	дүн	хувь
Нүүрс олборлолт, мян.тонн	1 842.4	1 822.5	1 871.8	49.3	2.7
Дулаан дамжуулалт, мян.гкал	90.0	85.9	95.2	9.3	10.8
Талх, нарийн боов, тонн	85.0	88.5	74.3	-14.2	16.1
Зайлуулсан хог хаягдал, мян.м3	20.0	20.2	24.3	4.1	20.3


Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 49.3 (2.7%) мянган тонноор өсч, үнийн дүнгээр 919.6 (0.9%) сая төгрөгөөр буурсан бол дулаан үйлдвэрлэлт биет хэмжээгээр 9.3 (10.8%) мянган гкал-аар нэмэгдэж үнийн дүнгээр 331.6 (4.9%) сая төгрөгөөр буурсан байна.

Талх нарийн боовны үйлдвэрлэлт өнгөрсөн оноос 14.2 (16.1%) тонноор буурч 82.1 (18.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол, зайлуулсан хог хаягдлын хэмжээ 24.3 мянган метр куб болж өмнөх оноос 4.1 (20.3%) мянган метр куб-ээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, жил бүрийн эхний IV сард, мянган тонн



### НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Нийтийн үйлчилгээний орлого 1535.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 40.5 (2.7%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний IV сард

Үзүүлэлт	I-IV			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	тоо	хувь
	сая төгрөг				
<b>Нийт орлого</b>	<b>1 471.2</b>	<b>1 495.0</b>	<b>1 535.6</b>	<b>40.6</b>	<b>2.7</b>
Орон сууц	421.4	355.6	412.1	56.5	15.9
Ус борлуулалт	540.0	536.5	544.7	8.2	1.5
Сувагжуулалт	476.1	489.6	511.5	21.9	4.5
Бусад	33.7	113.3	67.3	-46.0	-40.6

<sup>1</sup>-дахин их

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний IV сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлт
	сая төгрөг		
<b>Нийт дүн</b>	<b>314.8</b>	<b>302.3</b>	<b>96.0</b>
Тавлаг өргөө	66.3	61.0	92.0
Маргад өргөө	50.7	69.4	136.9
Сод хөгжил	64.7	58.0	89.7
Шинэ элч	65.6	58.2	88.8
Уурхайчин	33.2	28.7	86.5
Содон суварга	34.3	27.0	78.6

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 5 дугаар сарын 13

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
ТОГЛООМ 

Валютын ханш 



аппликейнаас

**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ аваарай**

**Data lab** | тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**

 [www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)

 [www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)